

switchasia



Funded by
the European Union



GLOBAL ALLIANCE
FOR GREEN AND
GENDER ACTION



AFD

“ХЯЛБАР ШИЙДЭЛ” АЯН

Сургагч багш нарт зориулав


2024 он



MGFC



MONGOLIAN
WOMEN'S
FUND



This report was produced with the financial support of the European Union. Its contents are the sole responsibility of the Switch Off Air Pollution in Mongolian cities project and do not necessarily reflect the views of the European Union.

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Уг гарын авлагад дурьдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг “Дулаан шийдэл II” төсөл бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

Танилцуулга

Төслийн товч танилцуулга

“Дулаан шийдэл II” төсөл нь Европын Холбооны Свич-Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй 2022-2026 онд хэрэгжих дөрвөн жилийн хугацаатай төсөл бөгөөд Жэрэс Олон Улсын Төрийн Бус Байгууллага удирдан ШУТИС-ийн дэргэдэх Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ХХК, Монголын Эмэгтэйчүүдийн сантай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь Монгол улсын барилгын салбарт нөөцөд хэмнэлттэй, бохирдуулагч багатай туршлагыг нэвтрүүлэх зорилгоор хүртээмжтэй, тохиромжтой шийдлүүд хөгжүүлэн хувийн сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм. Төсөл хэрэгжих хугацаанд 5,900 өрхөд эрчим хүчний хэмнэлттэй шийдэл хэрэгжүүлж 17,700 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар зорьж байна.

Дулаан шийдэл төсөл нь олон нийтэд дулаалгын ач холбогдлыг таниулан сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс “Хялбар шийдэл” олон нийтэд мэдээлэл олгох аяныг хэрэгжүүлдэг. Дулаан шийдэл I (2018-2022) төслийн хүрээнд нийт 674 өрхийг дулаалгын сургалтад хамруулж 18,200 орчим хүнд биет болон биет бус байдлаар мэдээлэл хүргэж ажилласан ба үүнээс 1,429 өрх байшиндаа хялбар дулаалга хийж, 274 өрхөд төслийн зүгээс 5см дээврийн дулаалга хийж амжилттай ажилласан байна.

Дулаан шийдэл II (2022-2026) төсөл хэрэгжсэн эхний 2 жилийн хугацаанд бид 943 өрхийг дулаалгын сургалтад хамруулж 60,000 орчим хүнд биет болон биет бус байдлаар мэдээлэл хүргэж ажилласан ба үүнээс 1,445 өрх байшиндаа хялбар дулаалга хийж, 249 өрхөд төслийн зүгээс 5см дээврийн дулаалга хийж өгсөн байна.

Гарын авлагын тухай:

Энэхүү гарын авлага нь “Хялбар шийдэл” аяны Сургагч багш нар болон Сайн дурын идэвхтнүүдэд дулаан алдагдал, байшин дулаалгын ач холбогдол, агаарын бохирдлын талаарх мэдээлэл болон сургалт хийх арга зүй зэрэг Төслийн мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээн таниулахад хэрэгцээт үр чадваруудыг олгох зорилготой. Уг гарын авлагыг ашигласнаар Та:

- ❖ “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд зохион байгуулдаг “Хялбар шийдэл” аяны талаарх ойлголт, мэдлэг мэдээлэл нэмэгдэнэ.
- ❖ Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол, жендерийн тэгш байдлын талаар олон нийтэд сурталчлах, мэдээлэл хүргэж чаддаг болно.
- ❖ Аяны хүрээнд олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг оновчтой төлөвлөх чиглэлээр чадавхажна.
- ❖ Олон нийтэд мэдлэг мэдээлэл хүргэх, оролцооны арга дээр суурилсан, үр өгөөжтэй сургалт зохион байгуулж чаддаг болно.
- ❖ Сургалтын үр дүнг үнэлж, дүгнэх, тайлагнах чадвар дээшилнэ.

АГУУЛГА

Бүлэг 1. Оролцооны сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад зориулсан зөвлөмж

1. Сургалтын бэлтгэл
 - 1.1 Сургагч багш гэж хэн бэ?
 - 1.2 Сургалтын бэлтгэл ажлыг хэрхэн төлөвлөх вэ?
 - 1.3 Сургалтын зорилго, хөтөлбөр боловсруулах
 - 1.4 Сургалтын бэлтгэл ажлыг хангах
2. Сургалт зохион байгуулах
 - 2.1 Сургалтын оролцооны аргуудын төрөл
 - 2.2 Сургалтын зураг хэрхэн авах вэ?
 - 2.3 Сургалтын тайлан хэрхэн бичих вэ?
 - 2.4 Биеийн хэлэмжийг сургалтад хэрхэн ашиглах вэ?

Бүлэг 2. Сургагч багшид зориулсан нэмэлт мэдээлэл

1. Дулаалгын талаарх мэдээлэл
2. Уур амьсгалын өөрчлөлт ба жендер
3. Агаарын бохирдол
4. Стандарт дулаалга

Бүлэг 3: Хялбар шийдэл аяны сургагч багш/сайн дурын идэвхтнүүд олон нийтийн сургалт зохион байгуулхад зориулсан чиглүүлэх алхам

1. Хялбар шийдэл аяны олон нийт/сайн дурын идэвхтнүүд, сургагч багш нарын танилцуулга, сургалтын дүрэм
2. Дулаан шийдэл II төсөл ба Хялбар шийдэл аяны тухай танилцуулга
3. Хялбар шийдэл аяны олон нийт/сайн дурын идэвхтнүүдэд зориулсан сургалтын зорилго, хөтөлбөр
4. Олон нийтийн/сайн дурынхны сургалтыг чиглүүлэх үе шат
5. Олон нийтийн/сайн дурынхны сургалтын үнэлгээ, дүгнэлт ба тайлан

Нэгдүгээр бүлэг

Сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад зориулсан зөвлөмж

Нэгдүгээр бүлгийн хичээлүүд нь “Хялбар шийдэл” аяны сургагч багш танд олон нийтийн хэрэгцээнд тулгуурласан хүртээмжтэй, үр ашигтай сургалтыг зохион байгуулахад туслах **суурь мэдлэг мэдээллийг** өгөх болно.

Энэ бүлэгт аяны сургагч багш гэж ямар хүн байх ёстой гэдгээс эхлэн сургалтын бэлтгэл ажлыг төлөвлөх, сургалтын үеэр ашиглах аргууд, оролцогчидтойгоо харилцах, сургалтын төгсгөлд тайлан дүгнэлт үнэлгээ хийх талаар **ерөнхий мэдээлэл** авах болно.

1.1 Сургагч багш гэж хэн бэ?

“Хялбар шийдэл” аяны сургагч багш нь олон нийтийг идэвхжүүлж, мэдлэг хандлагыг өөрчлөх,, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дулаалга, түүний ач холбогдол, дулаалгын төрлүүдийн талаарх өөрийн мэдлэгээ ямагт нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ. Мөн сургалтыг сайтар төлөвлөж, бэлтгэл ажлыг нарийн хангаж, сургалтыг зохион байгуулах болгондоо туршлага хуримтлуулах нь сайн сургагч багш бүрийн зайлшгүй мөрддөг дүрэм гэдгийг мартаж болохгүй.

Сургагч багш юуны өмнө сургалтын агуулгыг сайтар судалж, төслийн талаарх ерөнхий мэдээлэл, дулаалгын төрлүүд, түүнийг хэрхэн хийдэг, дулаан алдагдал гэж юу болох, дулаалгын ач холбогдол зэрэг сэдвүүдийн талаар цэгцтэй мэдээлэл хуримтлуулсан байхаас гадна агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, жендер, манлайлал зэрэг дэд сэдвүүдийн талаар сэдэвтэйгээ холбон ярих, тайлбарлах чадвартай байх ёстой. Мөн тухайн сэдвийн хүрээнд тодруулга хийх, асуултад хариулах, багын ажлыг чиглүүлэх, хэлэлцүүлгийг удирдах гэх мэт ажлыг хийж гүйцэтгэх тул юуны өмнө өөрийн мэдлэг, мэдээллийг цэгцлэх нь чухал юм.

Сургалтын явцад суралцагчдын харилцааг нээлттэй, уян хатан, чөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлж оролцогчид тухайн сэдвээр юу мэддэг байсан, юу шинээр сурав гэдэгт нь байнга хяналт тавьж дүгнэлт хийж байх нь зүйтэй.

Сургагч багш нь доорх чадваруудыг бүрэн эзэмшсэн байна:

- ❖ Цаг сайн баримталж, хөтөлбөрт заасан хугацааны дагуу сургалтыг зохион байгуулах
- ❖ Төслийн болон аяны талаар мэдээлэл хүргэхдээ өөртөө итгэлтэй, дур сонирхолтой, түүнийгээ өвөрмөц арга замаар бусдад ойлгуулан итгүүлдэг байх
- ❖ Аяны талаар, дулаалгын талаар хангалттай сайн мэдлэгтэй байх
- ❖ Сургалтын тайлан мэдээллийг бэлтгэх чадвартай байх

1.2 Сургалтын бэлтгэл ажлыг хэрхэн төлөвлөх вэ?

Сургалт амжилттай зохион байгуулах нь бэлтгэл ажлаас 100% шалтгаалдаг.

Сургалт зохион байгуулахын өмнө сургалтын бэлтгэл ажлыг сайн хийх шаардлагатай байдаг. Бэлтгэл ажилд сургалт зохион байгуулах анги танхим сонгох, захиалах буюу сургалтын танхим бэлэн байдалд байлгах, сургалтыг ямар сэдвийн хүрээнд хэдэн цаг заах, хэн хариуцаж зохион байгуулах тухай тусгасан хөтөлбөр боловсруулах, сургалтад ямар материал, тоног төхөөрөмж хэрэгцээтэйг тодорхойлох, бүрэн бүтэн байдлыг шалгах зэрэг орно. **Аяны үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн сургалтыг зохион байгуулахдаа ихэвчлэн хорооны иргэний танхимыг ашигладаг тул хорооны удирдлагатай урьдчилан тохиролцох шаардлагатай.**

Сургалтын бэлтгэл ажилд хангалттай цаг төлөвлөх хэрэгтэй.

Ихэнх тохиолдолд сургалтын бэлтгэл ажилд сургалт заах хугацаанаас хоёр дахин илүү цаг зарцуулдаг.

1.3 Сургалтын зорилго, хөтөлбөр боловсруулах

Сургалтын зорилго:

Сургалтын зорилгод оролцогчдод аяны чиглэлээр ямар мэдээлэл, мэдлэг ур чадвар эзэмшүүлэхийг хүсч байгаагаа тодорхой бичнэ.

Сургалтын зорилгыг тодорхойлох үйл явц нь сургалтад оролцогчдын талаарх мэдээлэл болон тэдний сургалтаас хүсэн хүлээж буй үр дүнтэй уялдаатай байна.

Тиймээс таны сургалтын зорилго тухайн сургалтаараа “Хялбар шийдэл” аяны үйл ажиллагаа, дулаан алдагдал, стандарт дулаалга, хялбар дулаалгын чиглэлээр ямар мэдээлэл хэрхэн өгөх, үүгээр дамжуулан ямар үр дүнд хүрэхийг зориж буй талаар дэлгэрэнгүй бичнэ.



Сургалтын хөтөлбөр:

Та сургалтын өмнө дэвшүүлэн тавьсан зорилгодоо хүрэхийн тулд сургалтын хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй. Хөтөлбөр хэрэгцээ шаардлагын дагуу боловсруулагдсан байх тусам түүнээс сургалтын үр дүн шалтгаална. Сургалтын хөтөлбөрт доорх зүйлсийг зайлшгүй тусгадаг. Үүнд:

- Сургалтын зорилго
- Сургалтын үндсэн болон дэд сэдэв
- Сургалт явагдах цаг хугацаа
- Сургалтын хэлбэр, арга зүй
- Сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүн
- Сургалтыг чиглүүлэх сургагч багш, хамтран ажиллах сайн дурын идэвхтэн, хороо дүүргээс хариуцаж хамтран ажиллах хүмүүс, байгууллагын нэр

Сургалтын хөтөлбөрийн загвар / Жишиг/

Сургалтын зорилго: “Хялбар шийдэл” аяны хүрээнд хялбар аргаар олцоц сайтай, гар доорх материалыг ашиглан байшингаа хэрхэн дулаалах аргын талаар мэдээ мэдээлэл олон нийтэд хүргэх, мөн сонирхсон иргэдэд стандарт дулаалгын төрлүүд, түүнийг санхүүжүүлэх боломжийг тайлбарлан, цэгцтэй мэдээлэл хүргэнэ.

Сургалтын байршил: ... Дүүргийн ... Хорооны иргэний танхимд

Огноо: 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр


Сургалтын сэдэв	Сургалтын цаг	Сургалтын арга	Хэрэглэгдэхүүн	Сургагч багш/байгууллагын ага
Дулаан шийдэл II төсөл ба Байшингаа хэрхэн дулаалах, Хялбар болон стандарт дулаалгыг хэрхэн хийх талаар мэдээллийг оролцогчдод өгөх	12:00 - 13:15	Мэдээлэл буюу powerpoint презентаци	Компьютер Проектор Загвар модон сууц Төслийн донор байгууллагууды	Ж.Чанцал, Хорооны нийгмийн ажилтан Дүүргийн Улаан

			н лого бүхий стенд Сургагч багшийн хантааз	загалмайн хороо
--	--	--	---	--------------------

1.4 Сургалтын бэлтгэл ажлыг хангах

Сургалтад оролцогчдын тоо болон сургалт явуулах арга барилаас шалтгаалан сургалт явуулах анги, танхимыг сонгох хэрэгтэй. Тиймээс сургалт явуулах байрыг сонгох, бэлтгэхдээ дараах зүйлсийг анхаараарай.

- Сургалтад оролцогчдод хүртээмжтэй тоогоор сандал байх
- Багаар болон тойргоор ажиллуулах аргуудыг ихэвчлэн ашиглах үед бичгийн хэрэгсэл, тараах материал, техник хэрэгсэл тавих зориулалт бүхий ширээнүүдийг сургалтын өрөөнд байрлуулж, хангалттай зай талбай байгаа эсэхийг шалгах
- Сургалтын өрөөний хана нь сургалтын явцад бичих цаас болон үзүүлэнг өлгөх, наахад тохиромжтой байх, байхгүй бол хангалттай тооны хөлтэй самбарыг байршуулах
- Сургалтын өрөөний хана эсвэл аль тохиромжтой хэсэгт төслийн санхүүжүүлэгч байгууллагуудын лого бүхий стендыг зайлшгүй байршуулах ба үйл ажиллагааг баримтжуулж зураг авах тохиолдолд эдгээр логог зурганд заавал багтааж өгнө.



Гэвч зарим хамтран ажиллахаар сонгогдсон дүүрэг, хороо сургалт явуулах байр хомс, сонголт байхгүй тохиолдолд тухайн сургалтын өрөө, байрыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан сургалтын бэлтгэлийг хангаж болно. Мөн сургалтын үеэр ашиглах цаас, макет, материалууд зэргийг урьдчилан бэлтгэх хэрэгтэй. Сургалтын хэрэгслийг сайн бэлтгэх нь ажиллах чадварыг нэмэгдүүлж, зохиогдож байгаа сургалтын ач холбогдлыг харуулахад тустай байдаг.

Сургалт эхлэхээс өмнө ямар техник хэрэгсэл шаардагдах талаар бодож төлөвлөх хэрэгтэй. Дулаалгын хялбар аргуудын талаар видео материал үзүүлэхэд телевизор, дэлгэц, слайд үзүүлэх проектор хэрэг болно. Дасгал тоглоомын үеэр ашиглах хөгжим ч бас хэрэг болж мэднэ. Сургалтынхаа үйл явцыг баримтжуулах шаардлагатай тул зургийн болон видео камер зэрэг тоног төхөөрөмж хэрэгтэй. Тиймээс ямар техник хэрэгслийг аль өдөр нь хэрэглэх билээ, хэнээс хаанаас авч болох талаар сайн бодох хэрэгтэй юм.

Сургалт зохион байгуулалтын ажилд бусдаас дэмжлэг авах шаардлага заримдаа гардаг. Сургалт зохион байгуулахад хамтран ажиллах сайн дурын идвэхтэн, сургагч багш нар сургалтын үеэр материал тараах, өрөөнд агаар оруулах, цайны завсарлагад бэлтгэх зэрэг ажлыг хариуцан сургагч багшийг сургалтаас хөндийрэхгүй байхад дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг. Сургагч багш ганцаараа бүгдийг хийж чадахгүй тул зохион байгуулж буй хүн тус бүрийн ажил үүргийг сургалтын өмнө тодорхой болгосон байх шаардлагатай.

Сургалтын бэлтгэл ажлыг шалгах хуудасны загвар / Жишиг/

Сургалтын бэлтгэл ажлын жагсаалт	Тэмдэглэгээ	Тайлбар
----------------------------------	-------------	---------

	Бүрэн	Дутуу	
1. Сургалтын хөтөлбөр (ППТ)			
2. Тараах материал (Гарын авлага, үнэлгээний хуудас)			
3. Сургалтад оролцогчдод мэдээлэл хүргэх (Сургалтын зарыг 3-4 хоногийн өмнө тараасан байна)			
4. Сургалтын өрөөг урьдчилан захиалж бэлтгэсэн байх (Хорооны ЗБ-тэй холбогдож иргэний танхимыг сургалтад ашиглахаар захиалах)			
5. Сургалтын үеэр ашиглах бичгийн хэсэгсэл болон оролцогчдод тараах сургалтын багц (Сургалтын загвар байшингууд, оролцогчдоор сургалтын үнэлгээ бөглүүлэх бал бэлтгэх)			
7. Сургалтад оролцогчдын ирцын бүртгэлийн хуудас (оролцогчдын нэрс, хаяг, утасны дугаар гэх мэт мэдээллийг цуглуулна)			
8. Техник хэрэгсэл, түүний бүрэн бүтэн байдал (Проектор, зөөврийн компьютер, сургалтын ППТ-тэй флаш, уртасгагч, HDMI хөрвүүлэгч)			
9. Сургалтын цайны завсарлагын цай кофе, хөнгөн зууш зэргийг бэлтгэх			
10. Сургагч багшийн хувийн бэлтгэл хангагдсан эсэх (аяны лого бүхий хантааз, төлөвлөгөө, цаг баримтлах)			
11. Сургалтын танхимд тавих төслийн санхүүжүүлэгчдийн лого бүхий стенд зэргийг бэлтгэх, байршуулах			

2. Сургалт зохион байгуулах

Дулаалгын сэдэвт сургалт нь зорилтот байршлууд дахь айл өрхүүдийг байшин сууцаа дулаалах, дулаан алдагдал, агаарын бохирдлын эсрэг бодитой арга хэмжээ авахыг уриалах зорилготой. Энэхүү иргэдийн оролцоонд тулгуурласан сургалтыг сургууль, цэцэрлэг болон хорооны иргэний танхим гэх мэт байршлуудад олон нийтэд нээлттэйгээр зохион байгуулдаг.

2.1 Сургалтын оролцооны аргуудын төрөл

Сургалтад янз бүрийн насны, өөр өөр ажил мэргэжилтэй, боловсролтой, зан араншинтай хүмүүс оролцдог. Сургагч багш сургалтад оролцогчдыг ямар зан ааштай хүн бэ гэдгийг таньж мэдсэнээр тэдгээр хүмүүст тааруулж сургалтын аргаа сонгох, мөн сургалтад идэвхтэй байлгах үйл ажиллагаануудыг сургалтын өмнө болон явцад төлөвлөж байдаг. Оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх, сургалтын талаарх мэдлэг мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх, сургалтыг сонирхолтой болгох зорилготойгоор оролцооны аргуудыг түлхүү ашигладаг. Сургалтын оролцогчид боловсролын түвшин өөр, мэдлэг чадвар хандлагын хувьд өөрсдийн гэсэн онцлогтой байдаг. Жишээ нь: Ганцаардмал оролцогч, дуугуй оролцогч, эелдэг оролцогч, гутранги үзэлтэй оролцогч, гэгээтэй ухаалаг оролцогч гэх мэт., Доорх хүснэгтэд “Хялбар шийдэл” аяны хүрээнд зохион байгуулах сургалтад илүү тохиромжтой, нийтлэг ашиглагдах аргуудыг хураангуйлан хүргэж байна.

№	Сургалтын арга	Онцлог
2	Хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг нь оролцогчдыг багт хуваан ажиллуулахад түгээмэл хэрэглэж ирсэн маш чухал аргуудын нэг юм. Сургагч багш нь оролцогчидтой хамтран хэлэлцүүлгийг явуулж болдог. Хэлэлцүүлгийг эхлүүлсний дараа сургагч багш нь хэлэлцүүлэгт оролцохгүй, харин ажиглагчийн байр сууринаас ханддаг. Танилцуулах хичээлийн дараа хэлэлцүүлэг явуулахад үр ашигтай байдаг бөгөөд бүлгийн гишүүдэд сонссон зүйлсээ өөрсдийн нөхцөлд хэрэглэх боломжийг олоход энэ арга тусалдаг.
3	Багаар ажиллах арга	Багаар ажиллах нь хүн бүр өөрийн санаагаа илэрхийлэх боломжийг бүрдүүлдэг. Тэд хоорондоо ярилцаж байх үедээ санаа бодлоо солилцож, өөрсдийн мэдлэг, туршлагаа бусадтайгаа хуваалцдаг. Бүх оролцогчдын оролцоог хангахад ашигладаг нийтлэг арга юм.
4	Үзүүлэн материал ашиглах арга	Үзүүлэн таниулах материалууд нь мөн сургагч багшийн хувьд хичээлийнх нь тулгуур болдог ба ярих зүйлийг нь сануулж өгдөгөөр тэмдэглэл хийх шаардлагыг багасгадаг. Жишээ нь: үзүүлэн байшинг сургалтын үед багуудад тарааж дулаалгын материалтай танилцаж, хэрхэн яаж дулаалах талаар хэлэлцэж цаашид ярилцах сэдвийн талаар сануулж байгаа юм.
5	Лекц	Сургагч багш лекцийн үеэр хичээлдээ бүрэн хяналт тавьдаг ба агуулга, цаг хугацаагаа нарийн төлөвлөж чаддаг. Лекц нь оролцогчдод шинэ сэдэв заах, дүгнэлтийг танилцуулах зэрэгт тохиромжтой.

2.2 Сургалтын зураг хэрхэн авах вэ?

Сургалт зохион байгуулагдсан эсэхийг баримтжуулах, тайлан мэдээ бэлтгэх, санхүүжүүлэгч байгууллагуудад илгээх зэрэгт сургалтын зургийг чанартай, үр дүнтэй, өгүүлэмжтэй авах нь маш чухал байдаг. Мөн сургалтын зураг нь санхүүгийн тайланд баримт болж ордог тул оролцогчдыг багтаан зураг авах нь чухал.

Сургагч багш Та зураг авахдаа, эсвэл хэн нэгэнд зураг авахыг даалгахдаа доорх зүйлсийг анхаарна уу:

- Нэг сургалтад хамгийн багадаа шаардлага хангахуйц гурван зургийг авна. Нэг зураг нийт оролцогчдыг харуулсан байх, нэг зураг нь сургагч багшийг болон зааж буй хичээл санхүүжүүлэгч байгууллагуудын логог харуулсан байх, нэг зураг нь бүлгийн болон бусад оролцооны аргуудыг харуулсан ойроос авсан зураг байх.
- Сургалт эхлэхээс өмнө нийт оролцогчдын зөвшөөрлийг авна. Сургалтын явцад зураг авах ба энэ нь төслийн сошиал медиа хаяг болон тайланд орно гэдгийг сануулна. Бүх оролцогчид зургаа авахуулыг зөвшөөрсөн байх ёстой.
- 16-аас доош насны хүүхдийн зургийг авахгүй байхыг хичээгээрэй, шаардлагатай бол олон нийтийн сүлжээнд зураг нийтлэх, хэвлэхдээ хүүхдийн нүүрийг бүдгэрүүлнэ.
- Зураг авахад тухайн агшны үйлдлийг харуулсан байх ба оролцогчид бүгд дуран руу харсан, зохиомол байж болохгүй.
- Төслийн нэр санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч нарын логог зураг тус бүр агуулсан байх ёстой. Үүнд санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагуудын лого бүхий стенд, слайд, хантааз, тараах материал зэргийн аль нэгийг зурганд зайлшгүй оруулах.
- Зураг нь оролцогчдын дүр төрх тод, гэрэл таарсан байх бөгөөд харагдах байдлын шаардлагыг хангасан байх ёстой


Жишээ нь:





2.3 Биений хэлэмжийг сургалтад хэрхэн ашиглах вэ?

Биеийн хэл нь таны ярьж буй хичээлийн агуулгыг дэмжиж өгдгөөрөө сургалтын нэг чухал хэсэг болдог. Сургагч багшийн юу хэлж байгаа нь чухал хэдий ч харин түүнийгээ хэрхэн илэрхийлж байгаа нь түүнээс ч илүү чухал.



Биеийн хэл буюу үггүй харилцаа нь нүдний харц, нүүрний хувирал, гар болон хөлийн дохио зангаагаар илэрч байдаг. Дохио зангаа бүр өгүүлбэр доторх үгтэй адил учраас түүний утга санааг сайн ойлгож мэддэг, зөв ашигладаг байх хэрэгтэй.

- ❖ Сургалтаа явуулж байхдаа аль болох бүх оролцогчид руугаа жигд харж байх хэрэгтэй. Урд талд сууж байгаа оролцогчид, эсвэл таныг анхааралтай сонсож байгаа хэсэг рүү нүдний харцаа чиглүүлээд яриад байх юм бол бусад оролцогчдын сонсох идэвх буурдаг. Иймд хараагаа байнга шилжүүлж, оролцогчдыг бүгдийг хамрахаар харцаа чиглүүлэх хэрэгтэй.
- ❖ Бүлгийн ажлын үеэр ч юм уу асуулт хариултын үеэр тантай ярьж, харьцаж буй хүний нүд рүү эгц харж яриарай.
- ❖ Мөн ярьж буй хүнийхээ хэлсэн зүйлд итгэлтэй бус байвал нэг нүднийхээ хөмсгийг өргөх, хэрвээ ярьж буй зүйлд нь гайхсан байдлыг харуулъя гэвэл хоёр нүднийхээ хөмсгийг дээш нь өргөх үйлдэл хийж болно.



Нүүрний хувирал нь хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгоход их тус болдог. Тиймээс та сургалтын үеэр аль болох инээмсэглэж, инээсэн царайтай байх хэрэгтэй.

Хэрвээ та хөмсгөө зангидсан байдалтай оролцогчид руугаа харах юм бол тэд таныг ууртай, сэтгэл дундуур байгаа юм байна гэж бодно. Мөн та эрүү шүдээ зуусан байдалтай байх юм бол таныг ууртай, сэтгэлийн дарамттай байгаа юм байна даа гэж бодно. Уруулаа унжуулсан байдалтай байвал та бусдад уйтгартай байгаагаа харуулж байна гэсэн үг. Тиймээс аль болох дээр дурдсан нүүрний хувирлыг сургалтын үеэр оролцогчид руугаа гаргахгүй байхыг хичээгээрэй.



Хэрэв сургалтаа зааж байхдаа гараа чанга атгасан байдалтай зогсох юм бол та бусдад хэтэрхий дарамттай байдалтай харагдах болно шүү. Та ярьж байгаа хүнийхээ ярианд анхаарлаа хандуулж, тухайн асуудлын талаар бодож байгаагаа харуулъя гэвэл гараа хацар дээрээ тавьсан байдалтай суух юм уу зогсох хэрэгтэй. Харин хуруунууд тань эрүүний дагуу нугалсан байдалтай харагдах юм


бол та бусдыг шүүмжлэх, таагүй дүгнэлт өгөх гэж байгаа байдлаа харуулна гэсэн үг. Гартаа чиглүүлэгч барих эсвэл шаардлагатай мэдээллийг заах, хэлж буй үгээ илэрхийлэхдээ гараа ашиглах нь тохиромжтой байдаг.



Сургалтаа бэлтгэх шатанд өөрийгөө толинд харж бэлтгэл хийж хэвшээрэй.

Сургалтын үеэр сургагч багш Та доорх биеийн хэлэмжийг анхаарна уу:

- ❖ Гараараа нүд, чихээ үрэх, эсвэл толгойгоо маажих бол хүмүүс таныг өөрийнхөө ярьж буй зүйлд энэ сургагч багш итгэл муутай л байна даа гэж бодно.
- ❖ Гарын алгаа дээш нь харуулсан байдалтай ярих юм бол та бусадтай нээлттэй харилцаж байгаагаа харуулж байна гэсэн үг.
- ❖ Гараа зөрүүлсэн байдалтай зогсох юм бол өөрийгөө хаалттай хүн гэж бусад бодогдуулах болно гэдгийг санаарай. Мөн хэлж буй оролцогчдын санааг хүлээн авахгүй, үгүйсгэж байна гэсэн үйлдлийг илтгэнэ.
- ❖ Та бусдын ярьж байгаа зүйлд оролцох хүсэл, сонирхолтой байгаагаа харуулахыг хүсвэл сандлынхаа ирмэг хавьцаа, урагшаа тонгойсон байдалтай суугаарай.
- ❖ Хөлөө зөрүүлж тавих эсвэл суух юм бол таныг сургалтад оролцогчид бидэнтэй санал нийлэхгүй байгаа юм гэж ойлгох болно шүү. Ер нь хөл, гараа зөрүүлсэн байдалтай зогсож, сууж байгаа хүнийг аливаа нөхцөл байдлын эсрэг санал бодолтой хүн байна гэж үздэг.
- ❖ Сургалтад оролцогчдынхоо өмнө халаасандаа гараа хийгээд, толгой мөрөө доош нь унжуулсан байдалтай зогсох юм бол хүмүүс таныг санаа сэтгэл нь тогтворгүй, гутранги хүн байна гэж ойлгох болно. Мөн оролцогчдын үл хүндэтгэсэн байдал шууд илэрхийлэгдэнэ.
- ❖ Та аль болох оролцогчдод сандарсан байдлаа харуулахгүй байх хэрэгтэй. Хэрвээ та стресстэй, сандарсан, ядарсан байдалтай харагдахгүй байя гэвэл дараах хөдөлгөөнүүдийг хийж болохгүй. Үүнд: байнга хоолойгоо засах, гараараа амаа хаах, хуруугаараа ширээ тогших, нүүр, уруулаа татвалзуулах, суудал дээр хавчигнах, байнга харандаа балаараа оролдох, исгэрэх шүгэлдэх гэх мэт.
- ❖ Оролцогчдынхоо анхаарлыг татъя гэвэл ярих үедээ Та нэг газраа зогсоод байх биш оролцогчдын урдуур болон дундуур явах хэрэгтэй байдаг. Энэ нь оролцогчид бие биенээ чөлөөтэй харах, бие биенийхээ нэрийг тогтоох таатай уур амьсгал төрүүлж, тэдний сонирхлыг төрүүлэх чөлөөтэй нөхцлийг бүрдүүлж өгдөг.



2.4 Сургалтын тайлан хэрхэн бичих вэ?

Сургалтын тайлан нь сургагч багшийн ажлыг үнэлэх, сургалтын талаарх мэдээллийг оролцогчид болон төсөл хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч нарт хүргэх гол хэрэгсэл юм. Хялбар шийдэл аяны сургалтын тайланг онлайн Google form хэлбэрээр авах ба сургалтын тайлантай хамт бусад шаардлагатай баримт бичгүүдийг хавсаргах шаардлагатай. Сургалтын тайлан бөглөх формын линк сургагч багш нар өгөгдөх ба тайлангийн форм нь дараах асуултуудыг багтаасан байна. Үүнд:

- Сургалтын нэр, зорилго
- Зохион байгуулагдсан байршил, он сар өдөр
- Хамтран зохион байгуулсан байгууллага, сургагч багшийн нэр
- Оролцогчдын талаарх мэдээлэл, ирц бүртгэлийн хуудас (үүнд: оролцогчдын нэр, хаяг, хүйс, утасны дугаар) ***Сургалтын ирцийн хуудас нь хамгийн чухал бичиг баримт бөгөөд ирцийн хуудсын дагуу



сургалтад оролцсон игэдээс утсаар мэдээлэл авч хялбар дулаалгын шийдлүүдийг хэрэгжүүлсэн эсэхийг асуудаг. Иймээс сургалтын ирц нь оролцогчдын овог нэр, хаяг, хүйс, утасны дугаар гэх мэт мэдээллүүдийг зайлшгүй багтаах шаардлагатай.

- Оролцогчдын бүртгэлийн нэгтгэл. Нийт хэдэн хүн оролцсон үүнээс эрэгтэй, эмэгтэй.
- Сургалтын үнэлгээний хуудасны нэгтгэл, дүгнэлт
- Оролцогчдын санал сэтгэгдэл / үүнд оролцогчийн талаарх мэдээлэл хаяг, нэр гэх мэт. Боломжтой бол сэтгэгдэл хэлж буй оролцогчийн зураг/
- Сургалтын дүгнэлт: Сургалтын талаарх сургагч багшийн нэгтгэл дүгнэлт (давуу тал, олж авсан сургамж, сургалтын үр дүнг сайжруулах санал)
- Сургалтын үеийн нийт оролцогчдын зураг, үйл явцын зураг
- Сургалт зааж буй сургагчийн зураг

Хавсралт материал: Сургалттай холбоотой фото зураг, сургалтын үеэр оролцогчдын хийсэн үзүүлэн, зураглал, хэлэлцүүлгийн тэмдэглэл г.м Доорх формыг сургалт хийхээс өмнө уншиж танилцан ямар ямар мэдээлэл оруулах шаардлагатайг мэдсэнээр цаг алдалгүй үнэн зөв бөглөх боломжтой болно. Тайлан ирүүлэх загварыг дараах зургаас харна уу.

Олон нийтийн сургалтын тэмдэглэл 2023

Сургагч багшид зориулсан сургалтын талаарх тэмдэглэл

Судалгаа бөглөсөн сургагчийн нэр *

Short answer text

Сургалт зохион байгуулсан дүүрэг *

1. Чингэлтэй дүүрэг
2. Баянзүрх дүүрэг

Сургалт зохион байгуулсан хороо *

Short answer text

Сургалт зохион байгуулсан огноо *

Month, day, year



Сургалт эхэлсэн цаг *

Time



Сургалт дууссан цаг *

Time



Оролцогчдын тоо *

эрэгтэй 7, эмэгтэй 5 гэх мэтээр хүйсээр нь тоог нь гаргаж бичнэ үү

Short answer text

Хэдэн хүн 5 айлд дулаалга хийхээр бүргүүлсэн бэ?

Short answer text

Сургалтын ерөнхий тэмдэглэл *

Сургалтын ерөнхий уур амьсгал, оролцогчдын хандлага, санаанд тод үлдсэн нөхцлийн талаар бичнэ үү

Long answer text

Ирцийн хуудасны зургийг оруулна уу *

!!!

 Add file

 View folder

Сургалтын үеийн оролцогчдын зураг *

Аяны стандыг оруулж авахыг хичээгээрэй :)

 Add file

 View folder

Сургалт зааж буй сургагч багшийн зураг *

Аяны стандыг оруулж авахыг хичээгээрэй :)

 Add file

 View folder

Сургалтын үйл явцын зургууд зураг *

чөлөөт зургуудаасаа оруулаарай :)

 Add file

 View folder

Хоёрдугаар бүлэг

Сургагч багшид зориулсан нэмэлт мэдээлэл

Байшин сууцаа дулаалах нь тухайн байшингийн насжилтыг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах гэсэн шууд нөлөөтэй байдгаас гадна хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, гэр бүлийн гишүүдийн өвчлөх нь буурах, эдийн засгийн хэмнэлт гарах зэрэг шууд бус олон эерэг нөлөөтэй байдаг. Байшингаа дулаалах нь зөвхөн өөрийн тав тухыг нэмэгдүүлэхээс гадна нийгэмд, эдийн засагт болон улсад ямар эерэг нөлөө авчирч буйг сургагч багш сайн ойлгосон байх ёстой.



Уур амьсгалын өөрчлөлт гэж юу вэ?

Хүний үйл ажиллагаанаас шалтгаалж дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй өөрчлөлтийг уур амьсгалын өөрчлөлт гэдэг. Уур амьсгалын өөрчлөлт нь нүүрстөрөгчийн давхар исэл болон метан зэрэг хүлэмжийн хийн ялгарлаас үүдэн бий болдог. Уур амьсгалын өөрчлөлт нь гамшгийн давтамж нэмэгдэх, ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, гол горхи ширгэх зэрэг үр дагавруудыг бий болгож бидний амьдралд сөргөөр нөлөөлж байна. Дэлхий бол тэр чигтээ нэг цөм бөгөөд нэг бүсэд бий болсон өөрчлөлт нь дэлхийн бусад бүх хэсэгт нөлөөлдөг юм.

Уур амьсгалын өөрчлөлт Агаарын бохирдолтой холбоотой юу?

Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол хоёр нь хоорондоо салшгүй холбоотой. Уур амьсгалын өөрчлөлтийг хүлэмжийн хийн ялгарал бий болгодог. Харин хүлэмжийн хий нь байшин сууцыг нүүрс түлж халаах, бензин/түлш хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл ашиглахад ихээр ялгардаг. Айл өрхүүдийн түлшний хэрэглээ, нам даралтын зуух, тээврийн хэрэгсэл, цахилгаан станц зэргээс хүлэмжийн хий ялгараад зогсохгүй утаа, нарийн ширхэгт тоосонцрыг үүсгэн агаарыг бохирдуулдаг. Бидний амьдарч буй Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын тоонд багтдаг бөгөөд агаарын бохирдлын 60 гаруй хувь нь түлшний хэрэглээнээс үүдэж байна.¹

Агаарын бохирдолд хэн хамгийн их өртөж байна вэ?

Амьсгалын замын өвчин, уушгины хатгалгаа, үрэвсэл зэргээс шалтгаалсан өвчлөл, нас баралтад агаарын бохирдол ихээр нөлөөлж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын оршин суугчдын 10,000 хүн тутамд амьсгалын замаар халдвар авах тохиолдлууд 2.7 дахин нэмэгдсэн.²


Агаарын бохирдолд илүү өртөмхий бүлгүүдийг тодорхойлбол:

Өндөр настан:

Өндөр настай хүмүүсийн эрүүл мэндэд агаарын бохирдол сөргөөр нөлөөлж амьсгалын замын, зүрх судасны, төв мэдрэлийн системийн өвчлөл, харшлын, удамшлын эмгэг, хавдар зэрэг өвчнүүдийн тархалт, тохиолдлын түвшнийг ихэсгэж байна. Утаа, нарийн ширхэгт тоосонцор нь хүний амьсгалах агаарыг бохирдуулж, хүчилтөрөгчийг багасгаж улмаар даралт ихсэх, цус харвах зэрэг өвчлөлийн

¹БСШУЯ, НУБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан, 2018. Боловсролын салбарт агаарын бохирдлын нөлөөллийг шуурхай үнэлэх. 2018 оны 8-р сар https://www.unicef.org/mongolia/media/911/file/Agaariin_bohirdol_report_mn.pdf

²Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл IV боть., Улаанбаатар., 2021., <http://www.hdc.gov.mn/file-category/56/>



эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Хүүхэд:

Улаанбаатар хотын агаарын бохирдол өндөртэй, гэр хороолол ихтэй дүүрэгт амьдардаг хүүхдүүдийн уушгины ажиллагаа хөдөө орон нутагт амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад 40%-аар бага байна.³ Агаарын бохирдлын улмаас хүүхдүүд бронхит, астам зэрэг суурь өвчтэй болж, хичээл сургуульд явж чадахгүйд хүрч, улмаар сурч, хөгжих бусад боломжуудаа алдаж байна. Насанд хүрсэн хүнтэй харьцуулбал хүүхэд хурдан, илүү олон давтамжтай амьсгалдаг. Иймд уушиг, амьсгалын замын өвчин тусах зэрэг эрсдэл өндөр байдаг.

Жирэмсэн эхчүүд:



Агаарын бохирдолд жирэмсэн эмэгтэйчүүд илүү өртөмтгий байдаг. Хэвлий дэх хүүхдийн уушги, амьсгалын замд нөлөөлж, хугацаанаас өмнө төрөх, ургийн гажиг үүсэхэд нөлөөлж байна. Өвлөөс зуны хооронд гэмдэглэгдсэн үр зулбалт 3.5 дахин гэсэн судалгаа байдаг.⁴

Жирэмсэн үедээ эсвэл төрсний дараах нярай үедээ агаарын бохирдолд өртөх нь нярайд танин мэдэхүйн хоцрогдол их бага хэмжээгээр үүсгэх эрсдэлтэй.

Суурь өвчтэй хүмүүс:



Бие махбод өвчлөмтгий байх суурь болохоос гадна өвдсөн үед бусад өвчин эмгэгтэй хавсарч хүндрэн үхэлд ч хүргэж болох өвчнүүдийг суурь өвчин гэж тодорхойлдог. Үүнд цус багадалт, Рахит Д витамин дутагдал, жин багатай байх, харшил, бронхит зэрэг өвчнүүд багтаж байдаг. Өвчний улмаас дархлаа

суларсан суурь өвчтэй хүмүүст угаарын хий, тоос тоосонцор гэх мэт бохирдлууд сөргөөр нөлөөлж өвчин ужгирах, амь нас эрсдэх аюул учруулдаг.

Агаарын бохирдлыг бууруулах хамгийн энгийн арга юу вэ?

Агаарын бохирдлыг бууруулах хамгийн энгийн аргуудын нэг бол нүүрс/түлшний хэрэглээг багасгах юм. Айл өрхүүд нүүрс/түлшний хэрэглээгээ багасгахад хэрэгжүүлж болох энгийн хялбар арга бол амьдарч буй байшин сууцны дулаан алдагдлыг бууруулах юм. Байшин сууцны дулаалснаар, эрчим хүчний хэмнэлт нэмэгдэж, өдөрт галлах тоо буурч, хэрэглэх нүүрсний хэмжээ багасна. Түлшний хэрэглээгээ бууруулснаар өрхөд эдийн засгийн хувьд хэмнэлт үүсэхээс гадна дулаан тав тухтай амьдрах боломж бүрдэж, өрхийн гишүүдийн эрүүл мэндэд ч эергээр нөлөөлнө.

Байшин сууц хаагуураа дулаан алддаг вэ?

Гэртээ даарч суух нь хэнд ч таалагдахгүй нь лавтай. Байшин сууц барихдаа зориулалтын бус, тохиромжгүй материалаар, зураг төсөлгүйгээр барьж, дулаалгаа зохисгүй хийснээс болж дулаанаа их хэмжээгээр алддаг. Танай байшин сууц аль хэсгээр дулаан алдаж байгааг таньж мэдэх нь маш чухал тул түгээмэл дулаан алдагддаг байна.

Дулаан алдагдлыг бууруулснаар үүсэх давуу тал юу вэ?

Дулаан алдагдлыг бууруулснаар дараах давуу талууд бий болно. Үүнд:

- ❖ Гэрийн дотор агаарын хэмийн хэлбэлзэл буурч тав тух сайжирна.
- ❖ Түлшний хэрэглээ буурч эдийн засгийн хэмнэлт бий болно.

³ Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам *тайлан*, НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 он <https://www.unicef.org/mongolia/mn/report>

⁴ “Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь” төсөл (2018-2023) НҮБ-ын Хүүхдийн сан, 2021 <https://www.unicef.org/mongolia/mn/reports>

- ❖ Дотор агаарын чанар сайжирна.
- ❖ Хүүхэд, гэр бүлийн гишүүд гэртээ даарч жиндэж ханиад томуу тусах нь багасна.
- ❖ Галлагаа хийх давтамж буурч, тоос тоосонцор багасна.

Байшин сууцныхаа дулаан алдагдлыг бууруулснаар нийгэм, эдийн засагт ямар өөрчлөлт гарч буй талаар Дулаан шийдэл I төсөлд хамрагдсан төлөөлөгч өрхүүдээс нарийвчилсан судалгааг 2020 онд авсан. Онцлох үр дүнгүүдээс дурдвал:



Гал түлэх ажлыг өрхийн гишүүдээс хэн хариуцан хийдэг талаар тодруулахад 10 айлын 7 нь эхнэрүүд гал түлэх үүргийг хүлээж, нөхөр, хүүхдүүд тусалдаг гэж хариулсан.



Өрх гэр, байшин сууц дулаан байх, галлах, хүүхдүүд, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн талаарх бүх асуудлуудыг өрх гэрийн эзэгтэй, эмэгтэйчүүд хариуцах нь цөөнгүй байдаг. Ийм учир дулаан алдагдлыг бууруулах, дулаалга хийх, эрүүл тав тухтай орчинд амьдрах шийдвэр гаргалт, хэрэгжилтэд эмэгтэйчүүдийн манлайлал чухал үүрэгтэй байдаг.



Гал түлэх тоо цөөрснөөр эмэгтэйчүүдийн хөдөлмөр хөнгөвчлөгдсөн байна. Үүнийг дагаад өөртөө болон гэр бүлдээ зарцуулах цаг нэмэгдсэн.



Байшин сууцаа дулаалснаар тохьтой байшин сууцтай болж, хамаатан садан, найз нөхдөө гэртээ урихад санаа зовох зүйлгүй болсон.

Стандарт дулаалгын мэдээлэл

Стандарт дулаалгыг мэргэжлийн хүмүүсийн тусламжтайгаар хийх ёстой. Иргэд өөрсдөө дур мэдэн зориулалтын бус тохиромжгүй материалаар, зураг төсөлгүйгээр барьж дулаалга буруу хийснээс болж байшин сууц дулаанаа их хэмжээгээр алддаг, мөн эдийн засгийн хувьд хохирдог. Дулаан алдагдал ихтэй байшин сууцад амьдарснаар санхүү болон эрүүл мэндээрээ хохирох тохиолдол

ихээхэн гардаг. Жишээ нь, модон бүтээцтэй байшингийн ханыг хөөсөнцрөөр дулаалдаг гэж сонсоод дулаалсан байдаг. Гэтэл мод өөрөө амьсгалдаг байгалийн материал. Тиймээс удаан амьсгалахгүй байхаараа зөөлрөөд үгжирдэг. Ингээд байшингийн үндсэн хийцийг муутгаж, цаашлаад нурах хүртэл эрсдлийг бий болгодог. Байшин сууцыг зориулалтын материалаар мэргэжлийн хүмүүсээр дулаалуулсанаар 20-50 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгох боломжтой. Стандарт дулаалгыг хийлгэхэд урьдчилан захиалга өгч Төслийн сургагдсан бригадаар техникийн үнэлгээ хийлгэсэн байх шаардлагатай.

Харин хялбар дулаалга бол байшингийн цонх, хаалга, шал, яндан, хана гэсэн хэсгүүдэд төвлөрч гарын доорх материалаар, хямд аргаар дулаалга хийх аргыг санал болгодог. Мөн хялбар дулаалгын шийдлүүдийн хувьд стандарт дулаалгатай болох хүртэлх байшингийн сийгэж буй хэсгийг битүүмжлэх арга хэмжээ тул Та өөрийн боломжиндоо тулгуурлан стандарт дулаалгыг технологийн дагуу хийлгэх тал дээр төлөвлөх нь зүйтэй. Байшин дотор сийгэж байгаа бүх хэсгийг битүүмжлэхэд илт дулаан болж байгаа нь мэдрэгддэг. Дулаалгын хялбар шийдлүүд хүн бүр хийх боломжтой бөгөөд бүх шийдлүүдийг хэрэгжүүлснээр эрчим хүчний 18 хувь хүртэлх хэмнэлт бий болгодог.

Дулаалгын төрлүүд

Дулаан шийдэл II төслийн хүрээнд ШУТИС-ын дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвөөс стандарт дулаалгын шийдлүүдийг боловсруулан гаргасан бөгөөд энэ чиглэлээр дулаалга хийх бригадуудыг сургаж, дадлаажуулдаг. Төслийн хүрээнд дээврийн, ханын, суурийн, шалны, бүтэн дулаалга гэсэн үндсэн төрлүүдийг санал болгодог бөгөөд үүнд доорх шийдлүүд орно.

❖ Дээврийн адрын хөндийн дулаалга

Байшин сууцны дээврийг дулаалахад хамгийн хялбар, зардал багатай, үр дүнтэй байдаг. Шувуун нуруутай байшингийн дээврийн хөндийд хэрэглэгчийн сонголтоор 15, 20см-ын зузаантай хөвөн материалаар дулаалга хийдэг. Материалын сонголт нь эрдэс хөвөн, чулуун хөвөн, хонины ноос зэрэг дулаан хадгалах зориулалттай байгалийн гаралтай амьсгалдаг материал байдаг. Энэхүү дулаалгын үндсэн материалыг ус, чийгнээс хамгаалах зориулалтаар уур, ус тусгаарлагч хальсыг хамгаалалт болгон ашигладаг. Дээврийн дулаалга хийлгэхээр сонирхож байвал тухайн байшин нь дам нуруу нь эвдрэл гэмтэлгүй, хотойлт үүсээгүй, дэвсгэр банз нь дулаалгын материал даах чадамжтай, хадаасны толгой зэврээгүй, борооны ус дэвэрээс шүүрдэггүй байх үндсэн шаардлагыг хангасан байх ёстой. Дээврийн адрын хөндий дулаалга хийснээр 20 - 35 хувийн эрчим хүчний хэмнэлт бий болдог.

❖ Суурийн болон шалны дулаалга

Байшин сууцыг сууриар хагарч, цуурч, бутарсан мөн сайтар дулаалж бариагүй зэрэг шалтгааны улмаас суурь хэсгээр дулаан алддаг. Сууриар дулаан алддаг талаар дийлэнх хүмүүс мэддэггүй. Суурийн болон шалны дулаалгыг хийснээр 10 хувийн эрчим хүчний хэмнэлт бий болох боломжтой бөгөөд шалнаас жиндэх асуудал шийдэгдэнэ. Дулаалгыг зориулалтын XPS төрлийн нягт хөөсөнцөр хавтангаар 10 см дулаалдаг. Хийгдэх хугацаа нь 04 сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд байдаг. Хөөсөнцөрийн гадуур өнгөлгөөний хавтан суурилуулж, дулаалгын материалыг гэмтлээс хамгаална.

❖ Цонх сайжруулалт

Байшин сууцны хана, суурь, дээвэр хэсгийг дулаалахаас гадна цонхны дулаан алдагдлыг бууруулах, дулаан алдагдалгүй цонх суурилуулах нь ач холбогдолтой. Чанар сайтай, дулаан алдагдалгүй гурван давхар шилтэй цонх суурилуулахыг төслийн стандарт дулаалгын хүрээнд санал болгож, чанарын шаардлага хангасан нийлүүлэгч компаниудтай хамтран ажилладаг. Материал өнгөний хувьд цагаан uPVC /хуванцар/, бор uPVC /хуванцар цонх/ байдаг. Цонхыг сайжруулснаар 8 орчим хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгодог.

❖ Бүтэн дулаалга

Байшин сууцтай айл бүр өөрийн хэрэгцээ шаардлага болон санхүүгийн боломжиндоо тулгуурлан дулаалгын төрлүүдээс сонгон, багцалж дулаалгын үйлчилгээ авах боломжтой. Хана, сууриа дулаалуулах, эсвэл дээвэр ханын дулаалга хийлгэх, цонхоо солиулж ханын дулаалга хийлгэх эсвэл дээрх бүх дулаалгыг хийлгэх гэх мэт өөр өөр сонголтоор бүтэн дулаалгын ажлыг хийж гүйцэтгэж болдог. Үндсэндээ стандарт дулаалгын хувьд нийт эрчим хүчний хэмнэлт хамгийн багадаа 20 хувь байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг.

Стандарт дулаалгын бүтээгдэхүүний төрлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах зургаас харна уу.



Дулаалга хэрхэн хийлгэх вэ?

1. Байшин сууцаа дулаалахдаа эзэлд хамрагдахаар төлөвлөж байгаа бол сургагдсан бригад/дулаалгын зөвлөхөөр техникийн үнэлгээ заавал хийлгэсэн байх хэрэгтэй. Техникийн үнэлгээ нь байршлаас шалтгаалан 30,000 - 70,000 төгрөг байдаг. Хэрэв захиалга өгөх бол 7505-2000 дуудлагын төврүү эсвэл Дулаан шийдэл Фейсбүүк хуудсаар холбогдон техникийн үнэлгээ хийлгэх захиалга өгнө.
2. Дулаалгын зөвлөхийн баталгаат техникийн үнэлгээний хуудсыг банк болон ББСБ-т үзүүлэн зээлийн хүсэлтээ өгдөг. Санхүүгийн байгууллага тус бүр өөрийн зээл олгох журмын дагуу таны зээлийг судалж, өөрсдийн шаардлагын дагуу материал бүрүүлэлтийг шаардана.

3. Зээл олгох шийдвэр гарсан даруйд хэрэглэгч ажил гүйцэтгэх бригадтай гэрээ байгуулна.
4. Сургагдсан дулаалгын бригад гэрээний дагуу дулаалгын ажилыг хийж гүйцэтгэнэ.
5. Дулаалгын ажил бүрэн гүйцэтгэсний дараа эрчим хүчний хэмнэлтийг тооцоолон аудиторын дүгнэлт гаргаж дулаан хэмнэлтийн гэрчилгээ гаргадаг.

Хэрэв хэрэглэгч өөрийн санхүүжилтээр дулаалга хийлгэх бол техникийн үнэлгээний хуудас гарсны дараа дулаалгын бригадтай хоёр тал тохиролцон гэрээ байгуулж дулаалгын ажил хийгдэнэ.



Дулаалга хэрхэн хийлгэх вэ?

- 1 Техникийн үнэлгээ**
7505-2000 дуудлагын төв рүү залган Техникийн үнэлгээ хийлгэх цаг аван дулаалгын зөвлөхөөр дулаан алдагдлаа хэмжүүлэн үнийн санал авна.
- 2 Зээл хүсэх**
Дулаалгын зөвлөхийн баталгаат үнийн саналыг хамтран ажилладаг банк болон ББСБ-д үзүүлэн зээл хүснэ.
- 3 Бригадтай гэрээ хийх**
Зээл гармагц ажил гүйцэтгэх бригадын ахлагчтай гэрээ байгуулна.
- 4 Дулаалгын ажил**
Ажил гүйцэтгэх Бригадын ахлагчтай гэрээ байгуулан гэрээний хүрээнд дулаалгын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5 Чанарын гэрчилгээ**
Дулаалгын ажлыг гүйцэтгэсний дараа эрчим хүчний аудиторын гэрчилгээ олгогдоно.

Хувийн санхүүжилт
Хувиараа санхүүжүүлж байгаа тохиолдолд 2-р алхмыг алгасан ажил гүйцэтгэгч бригадуудтай тохиролцон, гэрээ байгуулж ажлаа гүйцэтгүүлнэ.

Ногоон зээлд хамрагдах тухай

Төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаар (ББСБ) дамжуулан санал болгож буй ногоон зээлд хамрагдах боломжтой байдаг. Төслийн хувьд Хаан, Хас, Төрийн банк болон Транскапитал, Жи ЭсБи Капитал, ВишнФанд ББСБ-иудтай хамтран ажилладаг.

Хэрэглэгч банк бусаас зээл авахаар хүсэлт гаргасан тохиолдолд Төслийн зүгээс 5 сая хүртэлх төгрөгийн зээлийн хүүгийн 50 хувийн хөнгөлөлтийг 24 сарын хугацаатай үзүүлэх боломжтой

байдаг. Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын талаарх мэдээллийг дараах зургаас хүлээн авах боломжтой.

 ХААН БАНК ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Зээлийн нөхцөл • 20 сая хүртэлх • 30 сар хүртэлх хугацаатай • Жилийн 14.4 %-н хүүтэй Зээлийн шаардлага • Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх • Зээлийн муу түүхгүй байх Салбар нэгж	 ХАСВАНК ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Зээлийн нөхцөл • 50 сая хүртэлх • 30 сар хүртэлх хугацаатай • Жилийн 16.8%-н хүүтэй Зээлийн шаардлага • Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх • Зээлийн муу түүхгүй байх Салбар нэгж	 ТӨРИЙН БАНК ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Зээлийн нөхцөл • 15 сая хүртэлх • 50 сар хүртэлх хугацаатай • Жилийн 12-14.4%-н хүүтэй Зээлийн шаардлага • Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх • Цалин, түүнтэй адилгах орлогын 60%-иас хэтрэхгүй дүнгээр зээлээ хуваарийн дагуу хэсэглэн төлөх чадвартай
 GSB CAPITAL Зээлийн нөхцөл • Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт: 5 сая хүртэлх төгрөгийн зээлийн дүнд ногдох хүүгийн төлбөрийн 50%-ыг төслөөс хариуцна. • 30 сар хүртэлх хугацаатай • Сарын 2.4 %-н хүүтэй Зээлийн шаардлага • Тогтмол орлогын эх үүсвэртэй байх • Зээлийн муу түүхгүй байх Салбар нэгж • Да хүрээ • Сүхбаатар салбар • 21-р хороолол  7607-1818	 VisionFund MONGOLIA Зээлийн нөхцөл • Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт: 5 сая хүртэлх төгрөгийн зээлийн дүнд ногдох хүүгийн төлбөрийн 50%-ыг төслөөс хариуцна. • 24 сар хүртэлх хугацаатай • 3 сая хүртэл барьцаагүй • Сарын 3.5% -н хүүтэй Зээлийн шаардлага • Тогтмол орлогын эх үүсвэртэй байх • Зээлийн муу түүхгүй байх Салбар нэгж • Вишнфанд ББСБ-ын • Улаанбаатар хот дахь бүх салбар  7272-9779	 ТРАНСКАПИТАЛ Зээлийн нөхцөл • Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт: 5 сая хүртэлх төгрөгийн зээлийн дүнд ногдох хүүгийн төлбөрийн 50%-ыг төслөөс хариуцна. • 24 сар хүртэлх хугацаатай • Сарын 2.49%-2.99%-н хүүтэй Зээлийн шаардлага • Тогтмол орлогын эх үүсвэртэй байх • Зээлийн муу түүхгүй байх Салбар нэгж • Транскапитал ББСБ-ын • Улаанбаатар хот дахь бүх салбар  1800-1600

Гуравдугаар бүлэг

“Хялбар шийдэл” аяны үйл ажиллагааны хүрээнд явуулах олон нийтийн сургалт

Сургалтын зорилго

Энэхүү иргэдийн оролцоонд тулгуурласан сургалтыг сургууль, цэцэрлэг болон хорооны иргэний танхим гэх мэт байршлуудад олон нийтэд нээлттэйгээр зохион байгуулдаг бөгөөд олон нийт энэхүү сургалтад оролцсоноор өөрсдийн байшин сууцны дулаан алдагдлыг хэрхэн бууруулах, дулаалгын зөв зохистой стандартын дагуу хэрхэн дулаалах талаар мэдлэг мэдээлэл авах юм. Сургалтын хугацаа нь 80 минут байх ба 4 хэсэг бүхий ППТ-г үзүүлж шат дараатай, зохион байгуулалттай мэдээллийг олгож сургалтад идэвхтэй оролцсон, төслийн мэдлэг мэдээллийг цаашид олон айлд /5-аас дээш/ өрхөд дамжуулан хэрэгжүүлсэн СУРГАГЧ өрхүүдийг 5 см дээврийн дулаалгаар урамшуулдаг.

Сургалтын хөтөлбөр ба агуулга

Олон нийтийн сургалт нь төслийн танилцуулга, агаарын бохирдол ба дулаан алдагдал, стандарт дулаалга, хялбар дулаалгын талаарх сэдвүүдийг багтааж үндсэн 7 хэсгээс бүрдэнэ. Нийт 80 мин үргэлжилнэ. Сургалтын дэлгэрэнгүй хөтөлбөрийг доорх хүснэгтэд харуулав.

Олон нийтийн сургалтын хөтөлбөр			
	Сэдэв	Хугацаа	Шаардагдах нөөц
1	Сургалтын ППТ - 1р хэсэг: Төслийн болон хялбар шийдэл аяны танилцуулга	10 минут	ППТ Проектор Компьютер Төслийн болон аяны гарын авлага
2	Сургалтын ППТ - 2р хэсэг: Агаарын бохирдол Дулаан алдагдал Дулаалгын ач холбогдол Стандарт дулаалга Ногоон зээлийн талаар	15 минут	Төслийн болон аяны гарын авлага
3	Сургалтын ППТ - 3р хэсэг: Багаар ажиллах: Дулаалгыг хэрхэн хийх вэ?	15 минут	Загвар байшингууд, хялбар аргаар дулаалах материалын дээж Наадаг цаас
4	Сургалтын ППТ - 4р хэсэг: Видео хичээл: Хялбар дулаалга хийх зааварчилгаа	20 минут	Видео хичээл Мэдээлэл Асуулт хариулт Нэмэлт видео
5	Сургалтын дараах үйл ажиллагаа: гарын авлага тараах, хөршдөө мэдээлэл хүргэх, аяны үйл ажиллагаанд оролцох	10 минут	Гарын авлага: байшин дулаалах аргачлал

			Бүртгэл хийх: Аянд оролцох өрхүүдийн бүртгэл
6	Сургалтын дүгнэлт, үнэлгээ	10 минут	Дүгнэлт ярилцлага, санал болилцох, Үнэлгээний хуудас

1-р хэсэг. Төслийн танилцуулга

Мэдээлэл: Энэ хэсэгт илтгэгч нь оролцогчдод өөрийгөө танилцуулан төслийн талаарх ерөнхий мэдээллийг өгнө.

Хугацаа: 10 минут

Сургалт эхлэхээс өмнө сургагч багш компьютерээ проектортойгоо холбох, ППТ-г бэлтгэх, төслийн стенд болон гарын авлагуудыг байршуулах зэрэг бэлтгэл ажлуудыг хийсэн байх шаардлагатай. Сургалтын ирц хангалттай гүйцсэн тохиолдолд (хамгийн багадаа 10 хүн) илтгэгч нь сургалтыг эхлүүлнэ. Сургалтын ППТ-г эхлүүлээд сургагч багш өөрийгөө танилцуулсны дараа төслийн танилцуулгыг оролцогчдод хүргэнэ.

Слайд №	Тайлбар
1	 ПИТ-гээ харуулаад Хялбар шийдэл аяны сургалтад хүрэлцэн ирсэнд талархаж байгаагаа оролцогчдод илэрхийлнэ. Хялбар шийдэл аян нь Европын Холбооны санхүүжилттэй “Дулаан шийдэл 2” төслийн хүрээнд хэрэгжиж буй аян гэдгийг заавал дурдаж өгөх. Бид өнөөдөр та бүхэнд байшингаа хэрхэн дулаалах вэ, хялбар болон стандарт дулаалгын талаар сургалт орох болно гэдгээ танилцуулна.

“Сайн байцгаана уу, Намайг Гэдэг, Хялбар шийдэл аяны сургагч багшаар ажилладаг. Цаг гарган хүрэлцэн ирсэнд баярлалаа. Бидний өнөөдрийн Хялбар шийдэл сэдэвт сургалтыг Дулаан шийдэл 2 төслөөс боловсруулан танд хүргэж байна. Дулаан шийдэл төсөл нь 2018-2026 онд нийт 2 үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд Монгол улсын барилгын салбарт нөөцөд хэмнэлттэй, бохирдуулагч багатай туршлагыг нэвтрүүлэх зорилгоор хүртээмжтэй, тохиромжтой бүтээгдэхүүнийг хөгжүүлж, санхүүгийн шийдлийг санал болгон хувийн сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой.

Товчхондоо гэр хорооллын байшин сууцыг дулаалах замаар эрчим хүч болон түлшний хэрэглээг багасгаж цаашлаад хотын агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах нь төслийн зорилго юм. Сүүлийн 5 жилийн хугацаанд л гэхэд 3556 тонн хүлэмжийн хийн ялгарлаас болон 2411 тонн түлшний хэрэглээнээс сэргийлж чаджээ. Дулаалгын зах зээлийг бий болгосноор айл өрхүүд чанартай дулаалгын үйлчилгээ авах, дулаалгын үйлчилгээ үзүүлж буй нийлүүлэгч, бригадууд чадавхжих боломж бүрдэж байгаа юм. Төслийн хүрээнд стандарт дулаалгын шийдлүүдийг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг dulaalga.mn вэб сайт эсвэл ДУЛААН ШИЙДЭЛ Фейсбүүк хуудсаас авах боломжтой.

Дулаан шийдэл төслийн санхүүжүүлэгч байгууллагаар Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөр, Абби Пиер сан, Францын хөгжлийн агентлаг, ГАГТА сан ажилладаг бөгөөд төслийн хамтрагчаар Жэрэс ОУТББ, ШУТИС-ын дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын барилгын

үндэсний ассоциаци ТББ, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци болон Монголын Эмэгтэйчүүдийн Сан ажиллаж байна.

Дулаан шийдэл II төслийн хүрээнд Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлдэг бөгөөд дулаалгын ач холбогдлыг таниулан сурталчлах, иргэд гарын доорх материалаар байшин сууцны дулаан алдагдал, сийгэлтийг багасгах аргуудыг зааж өгөх, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой.

Нэмэлт мэдээлэл:

Дулаан шийдэл I төсөл (2018-2022)

Онцлох үр дүн:

- Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцны нийтлэг бүтэц, ямар материалаар баригдсан, айл өрхүүд байшин барихдаа ямар алдаа гаргадаг, дулаан алдагдал ямар түвшинд байгаа талаарх суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. Нийт сууцны 93 хувь нь дулаалах шаардлагатай гэсэн үр дүн гарсан.
- Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 73 бригадуудыг төслийн хүрээнд шат дараалсан сургалтад хамруулж стандартын дагуух дулаалгын ажил хийж гүйцэтгэх чадавхтай болгож сургаж дадлагдажүүлсан.
- Дулаалгын зах зээлд оролцогч талууд буюу бригад, нийлүүлэгч, эрчим хүчний аудитор, санхүүгийн байгууллага гэсэн талуудыг холбож, дулаалгын зах зээлийн системийг бий болгосон.
- 1546 өрх байшин сууцны дулаан алдагдлаа бууруулсан байна.

Дулаан шийдэл II төсөл (2022 – 2026)-ийн зорилго, зорилт

- Төслийн хүрээнд нийт 5900 өрх дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.
- Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлж, олон нийтийг идэвхжүүлэх замаар 4000 өрхийн дулаан алдагдлыг бууруулах
- Дулаалгын нэмэлт 3 шийдэл боловсруулж, сэргээгдэх эрчим хүчний 2 шийдлийг нэвтрүүлэх
- Ногоон зээлийн хүртээмж, сувгийг нэмэгдүүлэх буюу хамтран ажилладаг Банк, ББСБ-ын тоог нэмэгдүүлэх
- Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ажиллах 160 бригадыг нэмж сургаж дадлагдажуулах
- Сургалтын, төслийн үйл ажиллагаан багц боловсруулж, аймгийн төвүүдэд хэрэгжүүлэх, нэвтрүүлэх
- Төслийн үйл ажиллагааг холбогдох байгууллагад хүлээлгэн өгч, тасралтгүй, тогтвортой байдлыг хангах.

“Хялбар шийдэл” аяны тухай

“Хялбар шийдэл” аян нь “Дулаан шийдэл II” төслийн иргэдийн оролцоог хангах чиглэлд хийж буй үндсэн үйл ажиллагаа бөгөөд энэхүү аянаар дамжуулан:

- Агаарын бохирдолтой тэмцэхэд иргэдийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх;
 - Дулаалгын ач холбогдлын талаар олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах;
 - Байшингаа дулаалах бодит алхам хийхэд иргэдийг уриалах;
- Агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой

Хялбар шийдэл аянд яагаад нэгдэх ёстой вэ?

“Хялбар шийдэл” аян нь гарын доорх, олдоц сайтай материал ашиглан бага төсвөөр байшингийн цонх, хаалга, шал, хана болон яндангийн дулаан алдагдлыг бууруулах аргуудыг санал болгодог ороо давуу талтай.

Энэхүү гарын авлагыг ашиглан хялбар дулаалгыг гэртээ хэрэгжүүлснээр:

Тав тух нэмэгдэнэ;

Эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ;

Түлшний хэрэглээг бууруулж эдийн засгийн хэмнэлт бий болгоно;

Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хувь нэмэр

оруулж чадна.

Хялбар шийдэл аяны 2020 - 2024 оны байдлаарх үр дүн:


- 3023 өрх хялбар шийдлийг хэрэгжүүлсэн
- 623 өрхийн дээврийг 5 см эрдэс хөвөнгөөр дулаалсан байна
- 475 өрх цонх, хаалганы багцаар дулаалсан
- 120000 хүн онлайн болон биет байдлаар дулаалгын талаар мэдээлэл авсан.

2-р хэсэг. Агаарын бохирдол, дулаан алдагдал, дулаалгын ач холбогдол, стандарт дулаалгын танилцуулга


Мэдээлэл: Энэ хэсэгт илтгэгч нь оролцогчдоос асуулт асууж, харилцан ярилцаж дулаан алдагдал, дулаалгын ач холбогдлын талаар мэдлэг ойлголт өгнө.

Хугацаа: 15 минут


ППТ линк: https://www.canva.com/design/DAFjDfneTVc/p14crbdvYAsH-BZ9v5XF3g/view?utm_content=DAFjDfneTVc&utm_campaign=designshare&utm_medium=link&utm_source=publishsharelink

Слайд №	Тайлбар
1	 Өвөл гэхээр та бүхний санаанд юу бууж байна? гэж асуугаад хэд хэдэн хүний хариултыг сонсоно. Оролцогчдын саналыг сонсож дууссаны дараа “мандарин, шинэ жил, цана чаргаар гулгах, цасан дээр тоглох гэх мэт зүйлс байж болно” гэж хэлж болно. Судалгаагаар хүмүүс муу мэдээ сонсож айснаас бус эерэг мэдээлэл сонсож, эерэг үр дүн хүлээсэн үедээ өөрчлөлт хийдэг гэдгийг тогтоосон байдаг. Ийм учраас өвлийн талаарх гэгээлэг зүйлсийг нь яриад хотын маань хувьд өвөл ийм сайхан байж болох байсан. Гэвч өнөөгийн байдлаар хот маань ийм байдалтай байгаа гэдгийг дараагийн слайдаараа харуулна.
2	 Өвөл бол сайхан, бүх юм цагаан улирал боловч харамсалтай нь слайд дээр харагдаж байгаа агаарын бохирдол өвлийн улиралд эхэлдэг. Утаа бол зөвхөн гэр хороолол гэлтгүй зуслан, хотын төв, аймгийн төв гээд амьдарч байгаа бүх хүнд хамаатай асуудал болоод байна. Утаанаас болж олон айл өрх эрүүл мэнд, эдийн засгаараа хохирч байгаа.

3	АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭР: - ГЭР ХОРООЛ 80% - АВТОТРАНСПОРТ 10% - ЦАХААГААНЫ СТАНЦ 6% - ХӨГӨМӨЙ БОХИРДОЛ 4% Хүн бүр л агаарын бохирдол, өвөл болохоор яанаа, утаа хоолой хорсгож байна гээд янз бүрээр ярьдаг. Тэгвэл энэ агаарын бохирдол юунаас үүсээд байдаг юм бэ гэдэг дээр хэдүүлээ мэдээлэл авъя. За та бүхэн харж байна. Хамгийн их бохирдол үүсгэж буй эх үүсвэр бол өрхийн хэрэглээний зуух буюу түлш түлж утаа ялгаруулж байгаа яндан байдаг. 80 хувь гэдэг бол маш өндөр тоо. Энэ хувийг бид багасгасан үед агаарын бохирдлыг шийдэж чадна гэсэн үг юм. Улаанбаатар хотод 200000 өрх байшин буюу гэр сууцанд амьдардаг. Эдгээр өрхийн 95с дээш хувь нь энгийн галлагаатай буюу зуух яндантай байгаа. Өрх бүр сайжруулсан түлш/нүүрс түлдэг. Хэрэв бид түлш л түлж байгаа бол утаа гарна.
4	АГААРЫН БОХИРДОЛ = ДУЛААН АЛДАГДАЛ Бид яагаад нүүрс түлдэг вэ? Гэртээ даарахгүйн тулд. Танай байшин яагаад хүйтэн байгаад байна? Учир нь дулаалгагүй учраас. Дулаалгатай байшин дулаанаа маш удаан алддаг бөгөөд дотор агаарын хэм нэг хэмд удаан байдаг тул амьдарч буй хүмүүст тав тухтай байдаг. Дулаалгатай байшин дулаалгагүй байшингаас бага түлшээр халж, удаан дулаанаа хадгалдаг. Дулаалга хийснээр 75 хүртэлх хувийн эрчим хүчний хэмнэлт бий болгох боломжтой. Тиймээс бид агаарын бохирдолтой тэмцэхийн зэрэгцээ тав тухтай, хэмнэлттэй амьдрах гээд байгаа бол энэ дулаан алдагдлыг бууруулах хэрэгтэй. Сайн дулаалаагүй байшинд хоёр шуудай нүүрс хийх, сайн дулаалсан байшинд нэг шуудай нүүрс хийх үү гэдэг л асуудал юм. Дулаалга хийчихвэл танайх байшингаа цахилгаанаар халаах, нараар халаах нүүрснээс бусад эх үүсвэрээр халаахад эдийн засгийн хувьд боломжтой болно.
5	БАЙГАЛЬ ОРЧИН ЭРҮҮЛ МЭНД Нөгөө талаас агаарын бохирдол нь бидний эрүүл мэнд амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд нөлөө үзүүлж, бидний ирээдүйд аюул учруулж байгаа нь харамсалтай. /Бүлэг 2-т байгаа уур амьсгалын өөрчлөлтийн талаар ярих/
6	ДУЛААН АЛДАЖ БҮЙГ ЯАЖ МЭДЭХ ВЭ? 1. ЦАНГАЛТ 2. МӨСТӨЛТ 3. ЧИЙГ 4. ХАР ТОЛБОО Хүн ханиад хүрэхэд ямар шинж тэмдгүүд илэрдэг билээ? халуурах, ханиалгах, нус гоожих гэх мэт шинжүүд илэрдэг. Үүнтэй адил дулаан алдагдаж буйг дараах шинж тэмдгээр мэдэж болно. Та бүхэн энэ слайд руу хараарай. Цанталт, мөстөлт, чийг бас хар толбо. Дараа нь танай байшинд ийм шинж тэмдгүүд байна уу гэж оролцогчдоос асууна.

	Оролцогчдын хариултыг сонсоорой. Ихэвчлэн хүмүүс хар толбыг нэрлэдэг. Байшин төдийгүй орон сууцанд хүртэл энэ хар толбо үүссэн байдаг. Хар толбо буюу хар мөөгөнцөр бол хамгийн аюултай, амьсгалын замын өвчлөл, астма, харшил үүсэх суурь болох тохиолдлууд байдаг.
7	 Энэ хар мөөгөнцөр хаана үүсээд байна танайх яг тэр хэсгээрээ дулаан алдаж байна гэсэн үг. Таны нүүрс түлж бий болгосон дулаан яг тэр хэсэг дээр очоод гадагш алдагдахдаа цан цохиж, чийг үүсгэж байгаа хэрэг. Байнга цан цохиж, чийгтэй байгаа тэр хэсэгт хар мөөгөнцрийг бий болгодог. Энэ мөөгөнцрөөс бүрмөсөн салах цорын ганц арга бол цан цохихыг нь зогсоох бөгөөд харин дулаан алдагдлыг зогсоохоос нааш цан цохихыг зогсоох боломжгүй. Хар мөөгөнцөр байж л байдаг шүү дээ гэж үл тоож болохгүй. Ийм байшинд амьдрах нь эрүүл мэндэд муу. Бага насны хүүхдийн эрхтэн тогтолцоо, тархины хөгжилд муугаар нөлөөлдөг. Ханиад хүрээд өрхийн эмнэлэгт очихоор харшлын гаралтай ханиад хүрсэн байна гэж хэлдэг. Угтаа тэр харшил үүсгэгч нь мөөгөнцөр юм. Ийм агаараар амьсгалсан хүүхдийн тархинд гэмтэл үүсдэг бөгөөд үүнээс үүдэлтэй янз бүрийн өвчлөлүүд үүсдэг. Үүнийг нь бид хүүхэд өвдчихлөө л гэж ярьдаг болохоос биш яг энэ мөөгөнцөрөөс өвчин гараад байгааг мэддэггүй.
8	 Дулаан алдагдалтай байшинд амьдрах сөрөг нөлөөллийн талаар оролцогчдоос асуух. Дараа нь слайд дээр байгаа өвчлөлүүдийг нэрлэн тайлбарлах. Жишээ нь, өрөөний дотоод агаарын хэмийн 2 градусын өөрчлөлт л гэхэд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж эрүүл мэндийн судалгаа байдаг.
9	 Танай байшин аль хэсгээрээ дулаан алддаг вэ гэж оролцогчдоос эхлээд асууна. Асуусны дараа энэ слайд дээр байгаа зургийг үзүүлнэ. Ихэнхдээ хүмүүс манайх шалаараа дулаан алдаад байна гэж хариулдаг. Хүйтэн агаар гэрийн доод хэсгээр тархдаг учир тэгж санагддаг. Гэхдээ байшингийн суурь хагаралтай тохиолдолд шалаараа сийгэх нь бол маш их дулаан алдагдал үүсгэдэг. Гэвч байшинг бүтээцээр нь авч үзэхэд хананаас 34 хувь буюу хамгийн их дулаан алдагдаж байна. Ийм байхаас ч аргагүй юм. Учир нь хана бол байшингийн хамгийн том талбайг эзэлдэг. Тэгвэл энэ дээрвэс яагаад ханатай бараг адил хэмжээний дулаан алдаад байгаа юм гэхээр физикийн хуулиар дулаан агаар дээшээ чиглэж байдаг. Бууз жигнээд тагийг нь авахаар уур нь эгц дээшээ явдаг. Үүнтэй адил байшин бол яг буузны жигнүүрийн зарчмаар ажиллаж байна гэсэн үг юм. Энэ хоёрыг бодоход харьцангуй дулаан алдаж байгаа хэсэг бол цонх 10 хувь, тэгээд хаалга ордог.
10	 Тэгвэл байшингаа яаж дулаалах вэ? (Хүмүүс бидний заах гээд байгаа дулаалгын аргыг стандарт дулаалгын аргатай холих гээд байдаг. Бид бол гэрт байдаг гарын доорх материал эсвэл хямдхан олддог материалыг ашиглан яаж энэ дулаан алдагдлыг бууруулах вэ гэдгийг ярих гэж байгаа учраас энэ слайд дээрх дулаалгын хоёр төрлийг ялгаад хэлээд өгөх хэрэгтэй.)

	Стандарт дулаалгыг мэргэжлийн хүмүүсийн тусламжтайгаар хийх ёстой. Иргэд өөрсдөө дур мэдэн зориулалтын бус тохиромжгүй материалаар, зураг төсөлгүйгээр барьж дулаалга буруу хийснээс болж байшин сууц дулаанаа их хэмжээгээр алддаг, мөн эдийн засгийн хувьд хохирдог. Байшин сууцыг зориулалтын материалаар мэргэжлийн хүмүүсээр дулаалуулсанаар 20-50 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгох боломжтой. Стандарт дулаалгыг хийлгэхэд урьдчилан захиалга өгч Төслийн сургагдсан бригадаар техникийн үнэлгээ хийлгэсэн байх шаардлагатай. Харин хялбар дулаалга бол байшингийн цонх, хаалга, шал, яндан, хана гэсэн хэсгүүдэд төвлөрч гарын доорх материалаар, хямд аргаар дулаалга хийх аргыг санал болгодог. Мөн хялбар дулаалгын шийдлүүдийн хувьд стандарт дулаалгатай болох хүртэлх байшингийн сийгэж буй хэсгийг битүүмжлэх арга хэмжээ тул Та өөрийн боломжиндоо тулгуурлан стандарт дулаалгыг технологийн дагуу хийлгэх тал дээр төлөвлөх нь зүйтэй. Байшин дотор сийгэж байгаа бүх хэсгийг битүүмжлэхэд илт дулаан болж байгаа нь мэдрэгддэг. Дулаалгын хялбар шийдлүүд хүн бүр хийх боломжтой бөгөөд бүх шийдлүүдийг хэрэгжүүлснээр эрчим хүчний 18 хувь хүртэлх хэмнэлт бий болгодог.
11	 Өмнөх слайдад хэлсэнчлэн стандарт дулаалга хийхийн тулд ямар материалаар эхлээд хэрхэн яаж хийх ээ сайн судалсан байх хэрэгтэй. Хана, дээвэр, шал, хаалга, цонх гэсэн 5 бүтээцэд стандарт дулаалга хийх боломжтой байдаг.
12	 Дээврийн дулаалгад эрдэс хөвөн, чулуун хөвөн гэх мэт амьсгалдаг буюу агаар нэвтрүүлдэг материалууд ашиглах нь зүйтэй. Дээврийн дулаалга бол бусад хийцийн дулаалгаас харьцангуй хямд, үр дүнтэй дулаалгын арга юм. Мөн хүссэн цагтаа зузааныг нь давхарлан нэмэх боломжтой байдаг.
13	 Ханын дулаалга дулаалга хийх гэж байгаа байшин модон, бүрэн цутгамал бүтээцтэй байна уу, тоосго эсвэл блокоор барьсан эсэхээс шалтгаалан хоёр төрлийн арга болон материалыг ашиглаж ханыг дулаалдаг. Холболттой ханын дулаалга - Блокон эсвэл тоосгон ханын бүтээцтэй байшинд EPS хөөсөнцөр материалаар 15см зузаантай дулаалга хийдэг. Агаар сэлтгэлттэй ханын дулаалга- Модон, эсвэл бүрэн цутгамал ханын бүтээцтэй байшинд агаар сэлтгэлттэй ханын дулаалгыг хөвөн төрлийн амьсгалдаг материалаар 15 см-ийн зузаантай хийдэг.
15	Байшин сууцыг сууриар хагарч, цуурч, бутарсан мөн сайтар дулаалж бариагүй зэрэг шалтгааны улмаас суурь хэсгээр дулаан алддаг. Сууриар дулаан алддаг талаар дийлэнх хүмүүс мэддэггүй. Суурийн болон шалны дулаалгыг хийснээр 10 хувийн эрчим хүчний

	СҮҮРИЙН ДУЛААЛГА Эрчим хүчний хэмнэлт 10% Хийдэг хугацаа 4/15-10/15  ШАЛНЫ ДУЛААЛГА Эрчим хүчний хэмнэлт 10% Хийдэг хугацаа 04/15 - 10/15 	хэмнэлт бий болох боломжтой бөгөөд шалнаас жиндэх асуудал шийдэгдэнэ. Дулаалгыг зориулалтын XPS төрлийн нягт хөөсөнцөр хавангаар 10 см дулаалдаг.
	ХААН БАНК ХЭРГЭЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Залын өмчлөлт • 20 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Залын шалдлага • Сурвалж 1-2 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Салбар нэгж • Дотоод байр • Бүтэц • Хөдөлж 10-15 жил хүртэл • Хөдөлж 10-15 жил хүртэл 1800-1917 ХАСБАНК ХЭРГЭЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Залын өмчлөлт • 20 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Залын шалдлага • Сурвалж 1-2 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Салбар нэгж • Дотоод байр • Бүтэц • Хөдөлж 10-15 жил хүртэл • Хөдөлж 10-15 жил хүртэл 1800-1918 ТӨВРИЙН БАНК ХЭРГЭЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ Залын өмчлөлт • 20 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Залын шалдлага • Сурвалж 1-2 сая хүртэл • 10-15 жилийн хугацаатай • Хөдөлж 10-15 жил хүртэл Салбар нэгж • Дотоод байр • Бүтэц • Хөдөлж 10-15 жил хүртэл • Хөдөлж 10-15 жил хүртэл 1800-1919	Байшин сууцаа дулаалахдаа зээлд хамрагдахаар төлөвлөж байгаа бол техникийн үнэлгээ заавал хийлгэсэн байх хэрэгтэй. Дулаан шийдэл төслийн дуудлагын төврүү 7505-2000 дугаарын утсаар дулаан шийдэл фэйсбүүк хуудсаар холбогдон техникийн үнэлгээ хийлгэх захиалга өгч дулаалгын зөвлөхөөр үнэлгээ хийлгэнэ. Дулаалгын зөвлөхийн баталгаат техникийн үнэлгээний хуудсыг банкинд үзүүлэн зээлийн хүсэлтээ өгдөг. Банкны зээл банкны өөрийн зээл олгоход тавигддаг шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу материал бүрүүлэлтийг шаарддаг. Зээлээ судлуулан зээл гарсаны дараа хэрэглэгч бригадтай гэрээ хийнэ. Үүний дараа дулаалгын сургагдсан бригад/дулаалгын зөвлөх дулаалгын ажлыг хийж гүйцэтгэнэ.
16	ӨНГӨ ҮЗЭЖ ХААН БАНК 1800-1917 ТАВ ТҮХ ХАСБАНК 1800-1918 ҮНЭЛЭЖ ӨСНӨ ТӨВРИЙН БАНК 1800-1919	За одоо дулаалга хийснээр ямар давуу тал бий болж байна вэ гэдгийг энэ слайдаас харцгаая. Жишээ нь, ногоон өнгөөр ялгасан байгаа нь стандарт дулаалга хийснээр өнгө үзэмж сайжирна, үнэ өснө. Хялбар дулаалга хийснээр богино хугацаанд бага зардлаар байшингаа дулаалах боломжтой. Аль ч дулаалгыг хийсэн бай эдийн засгийн хэмнэлт бий болно, эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх болно гэж хэлээд слайд дээрхийг дэлгэрүүлж уншиж өгөөрэй.

3-р хэсэг. Багаар ажиллах

Дулаалгыг хэрхэн хийх вэ?

Ажиллах хугацаа: 15 мин

Хялбар дулаалгыг хэрхэн хийх вэ асуултын дагуу оролцогчид багаар ажиллана.

3	Сургалтын ППТ - 3р хэсэг: Багаар ажиллах: Дулаалгыг хэрхэн хийх вэ?	15 минут	Жижиг багаар ажиллах Үзүүлэн материал ашиглах: загвар байшин, хялбар аргаар дулаалах материалын өөдөс Наадаг цаас
----------	--	-----------------	--

Сургагч багшийн тэмдэглэл:

Сургагч багш багийн ажил хийх дарааллын дагуу оролцогчдыг идэвхжүүлж багийн ажлын гүйцэтгэлийг хянаана.



- ◆ Нийт хэдэн оролцогч байгаагаас шалтгаалан 3-4 хүнтэй багуудад хуваана. **Багт хуваахдаа жендерийн тэгш оролцоог хангахыг анхаараарай.**
- ◆ Баг тус бүрд загвар байшин болон дулаалга хийх материалуудыг өгнө. Материалуудын нэрийг бичсэн, материал тус бүрийг дугаарласан байгааг оролцогчдод сануулна.

1	Макетны материалын лист	Дулаалга
2	Мөнгөлөг зөөлөвч	Цонх
3	Парлон	Цонх, хаалга
4	Замаска	Цонх
5	Цаасан скоч	Цонх
6	Силикон	Цонх
7	Жийргэвч наадаг резин	Цонх, хаалга
8	Мөнгөлөг зөөлөвч наалттай	Хаалга
9	3D Обой	Хана
10	Жийнс	Хаалга
11	Чулуун хөвөн	Хана, Дээвэр, яндан
12	Мөнгөлөг скоч	Яндан, цонх
13	Зузаан гялгар	Цонх
14	Модны өөдөс	Хаалга
15	Картон цаас	Шал
16	EPS Хөөсөнцөр	Хана - стандарт дулаалга
17	XPS хөөсөнцөр	Шал - стандарт дулаалга
18	Эрдэс хөвөн	Дээвэр, хана - стандарт дулаалга

- ◆ Та эдгээр материалыг ашиглан байшингаа хэрхэн дулаалах вэ? гэсэн асуултын дагуу оролцогчдыг 10 минутын хугацаанд багаар ажиллах даалгавар өгнө. Жишээлбэл, багууд цонхоо дулаалах материалаа сонгоод, материал дээр байгаа тоог наадаг цаасан дээрээ бичээд цаасаа загвар байшингийн цонхны дэргэд наана.
- ◆ Сургагч багш багийн ажлын дараа энэ материалыг цонхонд, хананд хэрэглэнэ гэсэн тайлбар өгөхгүй. Зөвхөн багуудын тайлбарыг сонсоно.

- Багийн ажлын дараа цонхыг ямар материалаар дулаалсан бэ? гэж асууна. За та бүхэн ямар материалаар дулаалснаа эргэн хараарай. Одоо видео хичээлээс хэрхэн дулаасныг харцгаах болно гэж хэлээд дараагийн үе шат руу шилжинэ.



4-р хэсэг. Видео хичээл: Хялбар

дулаалга хийх зааварчилгаа

Хугацаа: 15 мин


4	Сургалтын ППТ - 4р хэсэг: Видео хичээл: Хялбар дулаалга хийх зааварчилгаа	15 минут	Видео хичээл Мэдээлэл Асуулт хариулт
---	---	----------	--

Сургагч багшийн тэмдэглэл:

Видео хичээлийг ажиллуулах техник хэрэгслийн бүрэн байдлыг хангаж, дараах дарааллын дагуу хичээлүүдийг явуулна. Хичээл тус бүрийн өмнө дулаалгын онцлог байдлыг гол мессеж хэлбэрээр оролцогчдод танилцуулна.

“Дулаалгын Хялбар шийдэл” гарын авлагаа ашиглан видео хичээлийн дундуур оролцогчдод нэмэлт мэдээлэл өгч болно.

Видео хичээл №	Тайлбар
1. Цонхоо дулаалах хялбар арга	 10% цонх ЦОНХИЙН 10% ХУВИЙН ГЭЖ ТООЦОО ГАРДАГ БАЙНА. ЦОНХНЫ ТОО, ХЭР ЗӨВ СУУЛГАСАН ЭСЭХЭЭС ШАЛТГААЛАН ДУЛААН АЛДАХ ХЭМЖЭЭ ИХСЭНЭ ГЭСЭН ҮГ ЮМ. ТИЙМЭЭС ЦОНХЫГ САЙТАР ДУЛААЛАХ ёстой” гэсэн мессежийг оролцогчдод хэлээд видеоогоо эхлүүлнэ. - Сургагч багшийн зүгээс тайлбар хийх шаардлагагүй. 3 минутын бичлэг байгаа, анхааралтай сайн ажиглаж сонсоорой гэдгийг оролцогчдод сануулна. - Видео хичээл дууссаны дараа “цонхыг бол хамгийн хямдхан дулаалах боломжтой хэсэг бөгөөд та байшингаа дулаалахаар шийдсэн бол цонхноосоо эхлээрэй” гэж дүгнэж хэлээд энэ хичээлийг өндөрлөнө https://www.youtube.com/watch?v=gZn7a9ROS68 https://youtu.be/pWzjj3jrAHI https://www.youtube.com/watch?v=hRwNDhhYGUA https://www.youtube.com/watch?v=Lma83FKvhdo

2. Хаалгаа дулаалах хялбар арга	 ■ Хаалгаа юугаар дулаалсан бэ? гэж оролцогчдоос эхэлж асуугаад хариултыг сонсоно ■ “Хаалгаар бид 8 хувийн дулаан алддаг байна. Хаалттай хаалга хүртэл дулаан алддаг гэдгийг та мэдэх үү, хүн орох гарах тоолонд энэ тоо нэмэгдэнэ гэхээр хаалгыг зайлшгүй дулаалах хэрэгтэй” гэсэн мессежийг хэлсний дараа видеог эхлүүлнэ ■ “Хаалга, цонх бол дулааныг барьдаг гол зүйл учраас хаалга, цонхоо сайн дулаалаарай, хаалттай байгаа хэрнээ дулаан алдана гэдэг бол үнэхээр харамсмаар зүйл юм шүү” гэж хэлээд энэ хичээлийг өндөрлөнө. https://youtu.be/9hy8ydBrtaA https://www.youtube.com/watch?v=a0C-NZyjHcE
3. Шалны дулаан алдагдлаа бууруулах хялбар арга	 Олон хүмүүс гэр нь сэрүүн байгааг гол шалнаас дулаан алдсантай холбож ойлгодог. Гэтэл шалнаас 6 хувийн л дулаан алддаг байна. “Халуун агаар дээшээ хөөрдөг учраас доор хүйтэн агаар л үлдэнэ. Байшин шалнаасаа дулаан алдаад байгаагаас байшин чинь хүйтэн болоод байгаа биш, харин угаасаа байшин нь дээвэр рүүгээ дулаан алдаад байгаа учраас хүйтэн байгаа, бас та даараад байгаа мэдрэмжээсээ болоод шалнаас дулаан алдаад байна гэж бодож байгаа юм шүү” гэдгийг оролцогчдод сануулан видео хичээлээ эхлүүлнэ. Шал дулаалах хялбар шийдэлтэй та бүхэн танилцлаа, одоо хананы дулаан алдагдлаа бууруулах хялбар аргатай танилцах дараагийн хичээлээ үзье гэж хэлээд дараагийн видео руу шилжинэ. https://youtu.be/QYiIaEPxXM8
4. Хананы дулаан алдагдлаа бууруулах хялбар арга	 Хананаас 34 хувийн дулаан алдагдал бий болдог гэдгийг бид өмнөх слайдаас ч харсан байгаа. Ханыг стандартын дагуу дулаалахад нэлээд хөрөнгө шаардагддаг. Одоо харин ханын дулаан алдагдлыг бүрэн биш ч тодорхой хэмжээнд бууруулдаг хана дулаалах хялбар аргатай танилцъя гээд видеоогоо эхлүүлнэ. https://youtu.be/rvW_UZAdiZg https://www.youtube.com/watch?v=l8bHaD14aNk
5. Яндан хоолой дулаалах	 Яндан дулаалгыг нэг удаа хийсэн тохиолдолд олон жилдээ солих шаардлагагүй. Гэхдээ галын аюулгүй байдлыг маш сайн хангаж хийх ёстой гэдгийг сануулж видео хичээлээ эхлүүлнэ. Яндан https://www.youtube.com/watch?v=POMvZAUbjwQ

5-р хэсэг. Сургалтын дараах үйл ажиллагаа: гарын авлага тараах, хөршдөө мэдээлэл хүргэх, хялбар шийдэл аянд оролцох

Хугацаа: 10 мин

Энэ үе шатанд агаарын бохирдлыг хамтдаа шийдэх байшингаа дулаалсан 4000 өрхийг бий болгох үйл ажиллагааны талаар танилцуулна.

Сургагч багшийн тэмдэглэл:

- Сургалтын ППТ дээр байгаа “Хэрхэн СУРГАГЧ ӨРХ болох вэ?” слайдыг тайлбарлана.

Сургагч өрх болохын тулд:

Нэгдүгээр алхам:

- Өөрийн байшинг хялбар аргаар дулаална.
- Дулаалга хийсэн байшингийн зургаа хариуцсан сайн дурын идэвхтэнд илгээнэ.

Хоёрдугаар алхам:

- 5 айлд хялбар дулаалгыг зааж өгөх
- 5 айл хялбар дулаалга хийхэд туслах
- 5 айлын дулаалга хийсэн зураг сайн дурын идэвхтэнд илгээх

Аяны зүгээс Сургагч өрх болсны урамшуулал болгож үнэ төлбөргүй 5 см дээврийн дулаалгыг байшинд нь хийж өгдөг нь Сургагч өрхүүдийг идэвхжүүлж урам зориг өгдөг юм.

- Байшингаа хэрхэн дулаалах мэдээлэл бүхий гарын авлагыг хүн бүрд өгнө
- Хөршдөө мэдээлэл өгөх хүсэлтэй хүмүүсийг бүртгэж 5 гарын авлагыг нэмж тухайн хүнд өгнө



Project/Төсөл : SOAP 2				
Activity/Үйл ажиллагаа : Сургагч өрхийн бүртгэл				
Location of the workshop/уулзалтын байршил :				
Оролцогчдын хуудас		date/Огноо		
No.	Овог нэр/First and last names	Хүйс/gender г	Утасны дугаар/Phone	Гарын үсэг/Signature
1		☐ Эр ☐ Эм		
2		☐ Эр ☐ Эм		
3		☐ Эр ☐ Эм		
4		☐ Эр ☐ Эм		
5		☐ Эр ☐ Эм		
6		☐ Эр ☐ Эм		
7		☐ Эр ☐ Эм		
8		☐ Эр ☐ Эм		
9		☐ Эр ☐ Эм		
10		☐ Эр ☐ Эм		
11		☐ Эр ☐ Эм		
12		☐ Эр ☐ Эм		
13		☐ Эр ☐ Эм		
14		☐ Эр ☐ Эм		
15		☐ Эр ☐ Эм		
16		☐ Эр ☐ Эм		
17		☐ Эр ☐ Эм		
18		☐ Эр ☐ Эм		
19		☐ Эр ☐ Эм		

6-р хэсэг. Сургалтын дүгнэлт, үнэлгээ

Хугацаа: 20 мин

Энэ үе шатанд “Та энэ хялбар аргаар байшингаа дулаалах уу?” гэсэн асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлэх юм.

Сургагч багшийн тэмдэглэл:

- ◆ “Та энэ хялбар аргаар байшингаа дулаалах уу?” гэсэн асуултын дагуу оролцогчдын санаа бодлыг сонсоно. Оролцогчдын саналыг тэмдэглэж авна.
- ◆ Хялбар аргаар цонх, хаалга, хана дулаалах бас өөр шийдлүүд байна. Та бүхэн сонирхож байвал богино бичлэгүүд үзүүлье. Эсвэл та бүхэн дараах линкээр орж үзэж болно.
<https://www.youtube.com/@GERESMongolia/videos>
- ◆ Сургалтад оролцсон нийт хүний тоогоор үнэлгээний хуудсыг бөглүүлж асуултын дагуу оролцогч бүрийн хариултын нэгтгэлийг хийнэ. Үнэлгээг бөглөхдөө оноогоор үнэлэх хэсэгт харгалзах оноотой нүдэнд тэмдэглэгээ хийх ба санал сэтгэгдэл хэсэгт төслийн үйл ажиллагаанд сайжруулалт хийх шаардлагатай зүйлс, санал, шинэ санаа зэргийг бичнэ.

“Хялбар шийдэл” аяны олон нийтийн сургалтын үнэлгээний хуудас

Овог нэр:

Амьдарч буй дүүрэг, хороо:

1. Та манай сургалтыг оноогоор үнэлнэ үү.
☐ 1 оноо ☐ 2 оноо ☐ 3 оноо ☐ 4 оноо ☐ 5 оноо
2. Бидний санал болгож буй шийдлүүдийн үр дүнтэй байдлыг оноогоор үнэлнэ үү.
☐ 1 оноо ☐ 2 оноо ☐ 3 оноо ☐ 4 оноо ☐ 5 оноо
3. Та сургагч багшийн ур чадварын оноогоор үнэлнэ үү.
☐ 1 оноо ☐ 2 оноо ☐ 3 оноо ☐ 4 оноо ☐ 5 оноо
4. Та байшингийн дээврийн судалгаанд хамрагдсан уу?
☐ Тийм ☐ Үгүй
5. Та бидний санал болгосон шийдлүүдийг гэртээ хэрэгжүүлэх үү?
☐ Тийм ☐ Үгүй
6. Та санал сэтгэгдлээ бичнэ үү.

.....

- ◆ Энэ хэсэгт олон нийтийн/сайн дурынхны сургалтын үнэлгээний хуудсыг ашиглан сургалтын үнэлгээгээ хэрхэн хийх ба сургалтын тайланд юу тусгах талаарх мэдээллийг өгөх болно.

- ◆ Сургалтад оролцсон нийт хүний тоогоор дээр дурдсан үнэлгээний хуудсыг бөглүүлж зургаан асуултын дагуу оролцогч бүрийн хариултын нэгтгэлийг хийнэ. Тухайлбал, нийт 15 хүн оролцлоо гэхэд 15 хүний хэд нь нэгээс зургаан асуултад “1-5” үнэлгээг тавьсныг нэгтгэнэ. Мөн үнэлгээний хуудасны 7-10-р асуултын хариултуудыг нэгтгэн дүгнэлт бичих хэрэгтэй.
- ◆ Санал хүсэлт гомдлыг хүлээн авах сувгуудыг танилцуулна.

Санал гомдлыг төсөл хэрэгжих хугацааны аль ч үед гаргаж болно. Санал гомдлыг холбогдох журмын дагуу амаар болон цахим хэлбэрээр гаргаж болно.

СХГУ хүлээн авах үндсэн сувгууд		
1	“Дулаан шийдэл II” төслийн Фейсбүүк хуудас	https://www.facebook.com/dulaanshiidel
2	Төслийн ерөнхий и-мэйл хаяг	dulaanshiidel@gmail.mn
3	Шууд утас/ Дуудлагын төв	7505-2000

- Бүгдээрээ өөрсдөө байшингаа хялбар аргаар дулаалахын зэрэгцээ хөрш, гэр бүл, ахан дүүс, гудамж, хорооныхондоо байшингаа дулаалахыг уриалцгаая гээд сургалтаа төгсгөнө.

_____ 000 _____



**"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН ХЯЛБАР ШИЙДЭЛ
АЯНТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ, СЭТГЭГДЭЛ, ГОМДЛЫГ
ДООРХ СУВГУУДААР МЭДЭЭЛНЭ ҮҮ**



7505-2000



"ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ"



dulaanshiidel@gmail.mn